



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 38 (467)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Хувь хүний орлогын албан татварын тухай*
- *Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Үнэлгээ хийх аргачлал, журам батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны аравдугаар сарын 13

№38 (467)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

613.	Хувь хүний орлогын албан татварын тухай (шинэчилсэн найруулга)	1129
614.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	1136
615.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай (шинэчилсэн найруулга)	1136
616.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	1144
617.	Хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай	1144

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

618.	Үнэлгээ хийг аргачлал, журам батлах тухай	Дугаар 176	1144
619.	Журам батлах тухай	Дугаар 184	1148

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

### ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ

*(шинэчилсэн найруулга)*

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Ерөнхий зүйл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1. Хувь хүний орлогын албан татвар /цаашид "албан татвар" гэх/-ын тухай хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль<sup>1</sup>, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

##### 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчээс бусад хувь хүний орлогод албан татвар ногдуулах харилцааг энэ хуулиар зохицуулна.

##### 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "гадаад улсад олсон орлого" гэж албан татвар төлөгчийн гадаад улсад хөдөлмөр эрхлэх, үйл ажиллагаа явуулах, хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө, эрх өмчлөх, эзэмших, ашиглах, шилжүүлэх, худалдах замаар олсон орлогыг;

4.1.2. "малчин өрх" гэж хувийнхаа өмчийн малыг байнга маллаж, ашиг шимээр нь үндсэн орлогоо олдог гэр бүлийг;

4.1.3. "мал бүхий этгээд" гэж энэ хуулийн 4.1.2-т зааснаас бусад мал өмчилж байгаа хувь хүнийг;

4.1.4. "суутгагч" гэж албан татвар төлөгчийн орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээдийг.

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ

##### Албан татвар төлөгч

##### 5 дугаар зүйл. Албан татвар төлөгч

5.1. Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл тийм орлого олоогүй ч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг

<sup>1</sup> Татварын ерөнхий хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1993 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

бүхий Монгол Улсад оршин суугч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн дагуу албан татвар төлөгч байна.

5.2.Энэ хуулийн 5.1-д заасан албан татвар төлөгчийг Монгол Улсад байнга оршин суугч болон Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч гэж ангилна.

## **6 дугаар зүйл. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч**

6.1.Дараахь хувь хүнийг Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч гэж үзнэ:

6.1.1.Монгол Улсад оршин суух байртай;

6.1.2.тухайн татварын жилд 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад амьдарсан;

6.1.3.гадаад улсад томилогдон ажиллаж байгаа Монгол Улсын төрийн албан хаагч.

6.2.Энэ хуулийн 6.1.2-т заасан хугацааг Монгол Улсын хилээр орсон өдрөөс хуанлийн хоногоор тоолох бөгөөд олон удаа орж гарсан тохиолдолд албан татвар төлөгчийн Монгол Улсад байсан хоногийн нийлбэрээр тодорхойлно.

6.3.Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн үндэстний байгууллага, түүний төрөлжсөн салбарт томилогдон ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүд нь Монгол Улсад оршин суугчид хамаарахгүй.

## **7 дугаар зүйл. Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч**

7.1.Монгол Улсад оршин суух байргүй, тухайн жилд 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад оршин суугаагүй хувь хүн нь оршин суугч бус албан татвар төлөгч байна.

7.2.Оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад байсан хугацааг энэ хуулийн 6.2-т заасны дагуу тодорхойлно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **Албан татвар ногдох орлого, албан татвараас чөлөөлөх орлого**

#### **8 дугаар зүйл. Албан татвар ногдох орлого**

8.1.Албан татвар төлөгчийн татварын жилд олсон дараахь орлогод албан татвар ногдуулна:

8.1.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;

8.1.2.үйл ажиллагааны орлого;

8.1.3.хөрөнгийн орлого;

8.1.4.хөрөнгө борлуулсны орлого;

8.1.5.малчин өрх, мал бүхий этгээдийн орлого;

8.1.6.шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого;

8.1.7.урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал;

8.1.8.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого;

8.1.9.шууд бус орлого.

#### **9 дүгээр зүйл. Албан татвар ногдох орлогыг тодорхойлох**

9.1.Дор дурдсан журмыг баримтлан албан татвар ногдох орлогыг тодорхойлно:

9.1.1.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсын нутаг дэвсгэрт болон гадаад улсад олсон орлогод албан татвар ногдуулна;

9.1.2.Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсын нутаг дэвсгэрт олсон орлогод албан татвар ногдуулна;

9.1.3.албан татвар төлөгч өөрөө буюу түүний өмнөөс хөрөнгө оруулсан, хуримтлуулсан бол уг хөрөнгийг албан татвар ногдох орлогод оруулан тооцсоныг албан татвар төлөгч нотлох үүрэгтэй бөгөөд хэрэв нотолж чадахгүй бол оруулсан хөрөнгө, хуримтлалын дүнг албан татвар төлөгчийн тухайн жилийн татвар ногдуулах орлогын дүнд оруулан тооцно;

9.1.4.бараа, ажил, үйлчилгээний хэлбэрээр хийгдсэн албан татвар ногдох орлогыг тодорхойлохдоо харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдсэн ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнийг жишиг болгоно;

9.1.5.харилцан хамаарал бүхий этгээдүүд зах зээлийнхээс хямд, эсхүл өндөр үнээр хоорондоо бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн, бараа, хөрөнгө шилжүүлсэн бол харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдсэн ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын зах зээлийн үнийг жишиг болгон татварын алба тодорхойлно.

9.2.Гадаад валютаар олсон орлого, гарсан зардлыг төгрөгт шилжүүлэхдээ Монголбанкнаас тогтоосон тухайн өдрийн ханшийг үндэслэнэ.

#### **10 дугаар зүйл. Харилцан хамаарал бүхий этгээд**

10.1.Албан татвар төлөгчтэй дор дурдсан харилцаатай бол "харилцан хамаарал бүхий этгээд" гэж үзнэ:

10.1.1. тухайн албан татвар төлөгчийн эцэг, эх, хүүхэд, өвөө, эмээ, ач, зээ бол;  
 10.1.2. тухайн албан татвар төлөгчийн ах, эгч, дүү, эсхүл тэдний хүүхэд бол;

10.1.3. тухайн албан татвар төлөгчийн эхнэр, нөхөр, эсхүл тэдний эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү бол;

10.1.4. тухайн албан татвар төлөгчийн буюу энэ хуулийн 10.1.1-10.1.3-т заасан харилцан хамаарал бүхий хувь хүний хяналтад байдаг хуулийн этгээд.

## 11 дүгээр зүйл. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого

11.1. Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараахь орлого хамаарна:

11.1.1. ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;

11.1.2. ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого;

11.1.3. ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг;

11.1.4. төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;

11.1.5. гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал;

11.1.6. үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого.

## 12 дугаар зүйл. Үйл ажиллагааны орлого

12.1. Үйл ажиллагааны орлогод хуулийн этгээд байгуулахгүйгээр бие даан мэргэжлийн үйлчилгээ, үйлдвэрлэл, арилжаа эрхэлж олсон дараахь орлогыг хамруулна:

12.1.1. эмч, хуульч, өмгөөлөгч, архитекторч, нягтлан бодогч, багш зэрэг мэргэжлээр ажиллаж олсон үйлчилгээний орлого;

12.1.2. хувиараа ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр олсон үйлдвэрлэл, арилжааны орлого.

12.2. Тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна.

## 13 дугаар зүйл. Хөрөнгийн орлого

13.1. Хөрөнгийн орлогод дараахь орлого хамаарна:

- 13.1.1. түрээсийн орлого;
- 13.1.2. эрхийн шимтгэлийн орлого;
- 13.1.3. ногдол ашгийн орлого;
- 13.1.4. хүүгийн орлого;
- 13.1.5. өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгийг бусдад ашиглуулснаас олсон орлого.

13.2. Түрээсийн орлогод хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө түрээслүүлсний орлого хамаарна.

13.3. Эрхийн шимтгэлийн орлогод дараахь төлбөр хамаарна:

13.3.1. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай<sup>2</sup> хуульд заасан зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг ашигласны төлбөр;

13.3.2. Патентийн тухай<sup>3</sup> хуульд заасан шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар ашигласны төлбөр;

13.3.3. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай<sup>4</sup> хуулийн дагуу барааны тэмдэг ашигласны төлбөр;

13.3.4. Технологи дамжуулах тухай<sup>5</sup> хуульд заасны дагуу технологи дамжуулсны төлбөр;

13.3.5. Үйлдвэрлэл, худалдааны талаархи болон шинжлэх ухааны туршилтад холбогдсон мэдээллийг ашигласны төлбөр;

13.3.6. Энэ хуулийн 13.3.1-13.3.5-д заасантай адилтгах бусад эрх ашигласны төлбөр.

13.4. Энэ хуулийн 13.1.3-т заасан ногдол ашгийн орлогод хувь нийлүүлсэн хуулийн этгээдээс ашиг хуваах, хувь хүртээх хэлбэрээр авсан мөнгөн болон мөнгөн бус орлого, түүний хүү хамаарна.

13.5. Энэ хуулийн 13.1.4-т заасан хүүгийн орлогод зээлийн хүү, харилцах дансны үлдэгдэл, мөнгөн хадгаламжийн хүү, батлан даалт гаргасны

<sup>2</sup> Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 7 дугаарт нийтлэгдсэн

<sup>3</sup> Патентийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 7 дугаарт нийтлэгдсэн

<sup>4</sup> Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 19 дүгээрт нийтлэгдсэн

<sup>5</sup> Технологи дамжуулах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 6 дугаарт нийтлэгдсэн.



төлбөр, өрийн бичиг /бонд/, хууль болон гэрээний дагуу авч байгаа хүү, анз хамаарна.

## 14 дүгээр зүйл. Хөрөнгө борлуулсны орлого

14.1.Хөрөнгө борлуулсны орлогод дараахь орлого хамаарна:

14.1.1.үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;

14.1.2.хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;

14.1.3.хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого.

## 15 дугаар зүйл. Шууд бус орлого

15.1.Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтнаас албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараахь бараа, үйлчилгээний орлогыг албан татвар ногдох шууд бус орлогод хамруулна:

15.1.1.үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн, түүнчлэн бэлнээр олгосон унааны мөнгө;

15.1.2.орон сууцны ашиглалтын зардлын төлбөр, бэлнээр олгосон байрны хөлс, түлшний зардал;

15.1.3.бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор;

15.1.4.ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгчийн болон бусад үйлчилгээ үзүүлсний зардал;

15.1.5.ажил олгогч, эсхүл бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр;

15.1.6.арилжааны эзэлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон эзэлийн хүүгийн зөрүү;

15.1.7.энэ хуулийн 15.1.1-15.1.6-д заасантай адилтгах бусад орлого.

15.2.Ажил үүргээ биелүүлэх нөхцөлийг нь сайжруулах зорилгоор ажил олгогчоос ажилтанд олгож байгаа дараахь шууд бус орлогыг албан татвар ногдох орлогод хамааруулахгүй:

15.2.1.тухайн ажлын байранд ажлын цагаар ажиллуулдаг цайны газар, кафе, амралтын өрөөнд бүх ажилтныг адил нөхцөлөөр хоолоор хангасан;

15.2.2.суурин газраас алслагдсан ажлын байранд ажилладаг ажиллагсдыг амрах байр, бусад үйлчилгээгээр хангах, тухайн ажлын байранд ирэх, буцахад ногдсон журмаар унаагаар үйлчилсэн;

15.2.3.орон сууц худалдан авах, барихад зориулж ажилтанд арилжааны эзэлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон эзэлийн хүүгийн зөрүү;

15.2.4.эмчилгээний зардал.

15.3.Энэ хуулийн 15.1-д заасан шууд бус орлогыг ажил олгогчоос уг орлогыг олгохтой холбогдон гарсан зардлын дүнгээр тодорхойлно.

## 16 дугаар зүйл. Албан татвараас чөлөөлөх орлого

16.1.Дараахь орлогыг албан татвараас чөлөөлнө:

16.1.1.хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөх олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж;

16.1.2.донорын олговор;

16.1.3.албан томилолтын зардал;

16.1.4.даатгалын нөхөн төлбөр;

16.1.5.Засгийн газрын өрийн бичиг

/бонд/-ийн төлбөр, хүү, анз;

16.1.6.хууль тогтоомжийн дагуу олгож байгаа хөдөлмөр хамгааллын болон дүрэмт хувцас, хор саармагжуулах ундааны үнэ, тэдгээртэй адилтгах бусад хангамжийн үнэ;

16.1.7.гамшгийн үед олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газар, хуулийн этгээд, иргэнээс Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, иргэдэд үзүүлж байгаа тусламж;

16.1.8.энэ хуулийн 6.3-т заасан хувь хүний цалин, нэмэгдэл;

16.1.9.энэ хуулийн 16.1.8-д заасан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн гадаад улсад олсон орлого;

16.1.10.хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хувь хүний орлого;

16.1.11.Монгол Улсын төрийн шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын ардын болон гавьяат цолтны шагнал, шинжлэх ухааны нээлтийн шагнал;

16.1.12.хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан эзэлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого.

16.2.Албан татвар ногдох орлогын дүнд албан татвараас чөлөөлөгдөх орлого хамаарахгүй.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

17 дугаар зүйл. Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

17.1.Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогод албан татвар ногдуулах орлогыг дараахь байдлаар тодорхойлно:

17.1.1.энэ хуулийн 11.1.1, 11.1.6-д заасан орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр;

17.1.2.энэ хуулийн 11.1.2-11.1.5-д заасан орлогын тухайд нийлбэр дүнгээр нь.

## 18 дугаар зүйл. Үйл ажиллагааны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

18.1.Үйл ажиллагааны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12.1.1-12.1.3, 12.1.5-12.1.14, 12.1.17, 12.1.19-12.1.26-д заасан зардлыг хасч, 12.2, 12.3, 12.5-12.8, 12.9-д заасан зарчмыг баримталж 13-15 дугаар зүйлийг дагаж өөрдөнө.

18.2.Энэ хуулийн 18.1-д заасан хасагдах зардал баримтаар нотлогдоогүй бөгөөд тухайн үйл ажиллагаатай холбоогүй, түүнчлэн албан татвар төлөгч хувийн хэрэгцээдээ зарцуулсан бол албан татвар ногдох орлогоос хасахгүй.

18.3.Албан татвар төлөгчийн гэр бүлийн гишүүдэд олгосон хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хэмжээтэй хувь тэнцүүлэн бодож хасагдах зардалд тооцно.

18.4.Албан татвар төлөгч нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнээс өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулсан байвал тэдгээрийг хасагдах зардалд тооцохгүй.

18.5.Албан татвар төлөгч нь үйл ажиллагаа эрхлэхэд ашиглаж байгаа машин, механизм, тоног төхөөрөмж, барилгыг гэр бүлийнхээ хэрэгцээнд нэгэн зэрэг ашиглаж байгаа бол ашиглалтын зардлыг хувь тэнцүүлэн тооцож хасагдах зардалд тусгана.

## 19 дүгээр зүйл. Хөрөнгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

19.1.Хөрөнгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг дараахь байдлаар тодорхойлно:

19.1.1.хөрөнгө түрээслүүлснээс олсон нийт орлогоос тухайн хөрөнгийг түрээслүүлэхтэй холбогдон гарсан зардлыг хассан зөрүүгээр нь;

19.1.2.эрхийн шимтгэлийн орлогыг дүнгээр нь;

19.1.3.ногдол ашгийн орлогыг дүнгээр нь;

19.1.4.хүүгийн орлогыг дүнгээр нь;

19.1.5.өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгөө бусдад ашиглуулж олсон орлогыг дүнгээр нь.

19.2.Албан татвар төлөгчийн хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж татан буугдсан бол тухайн аж ахуйн нэгжийн үлдсэн эд хөрөнгийг худалдаж олсон орлогоос татвар төлөгчийн хүртсэн хувийг тодорхойлохдоо түүний хувь нийлүүлэхдээ гаргасан зардлыг хасч тооцно.

## 20 дугаар зүйл. Хөрөнгө борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

20.1.Хөрөнгө борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг дараахь байдлаар тодорхойлно:

20.1.1.үл хөдлөх эд хөрөнгө борлуулснаас олсон орлогыг дүнгээр нь;

20.1.2.хувьцаа борлуулсны орлогын тухайд түүнийг борлуулсан үнээс уг хувьцааг худалдаж авсан үнийг хассан зөрүүгээр нь;

20.1.3.хамтран эзэмшиж байсан хувьцааг борлуулсан бол энэ хуулийн 20.1.2-т заасны дагуу хассан зөрүүг тодорхойлсны дараа тухайн албан татвар төлөгчид ногдох хэсгийн үнийн дүнгээр нь;

20.1.4.үнэт цаас борлуулсны орлогын тухайд түүнийг борлуулсан орлогоос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээр нь;

20.1.5.хөдлөх эд хөрөнгө борлуулснаас олсон орлогоос тухайн хөрөнгийг худалдан авсан болон ийнхүү худалдан авахтай холбогдон гарсан баримтаар нотлогдох зардлыг хассан зөрүүгээр нь.

## 21 дүгээр зүйл. Малчин өрх, мал бүхий этгээдийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

21.1.Малчин өрх, мал бүхий этгээдийн албан татвар ногдуулах орлогыг малын тоогоор тодорхойлно.

21.2.Малын тоог нэг хонин толгойгоор тодорхойлох бөгөөд үхэр, адуу тус бүрийг 5, тэмээг 2, ямааг 1.5 хонин толгойд илжүүлэн тооцно.

21.3.Албан татвар ногдуулах малын тоог тодорхойлохдоо өмнөх жилийн эцэст тоологдсон малын тоог үндэс болгоно.

21.4.Тухайн жилд албан татвар ногдуулах мал нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.2-т заасан гамшгийн улмаас хорогдсон бол нотлох

\* Гамшгаас хамгаалах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

баримтыг үндэслэн албан татвар ногдуулах нийт малын тооноос хасна.

## 22 дугаар зүйл. Бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

22.1. Дор дурдсан орлогод ногдуулах албан татварыг дараахь байдлаар тодорхойлно:

22.1.1. шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон болон тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр;

22.1.2. урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагналын орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн шагналын орлогын дүнгээр;

22.1.3. төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр;

22.1.4. шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Албан татварын хувь, хэмжээ

## 23 дугаар зүйл. Албан татварын хувь, хэмжээ

23.1. Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна.

23.2. Энэ хуулийн дараахь зүйл, заалтад дурдсан орлогод дор дурдсан хувь, хэмжээгээр тооцож албан татварыг тусгайлан ногдуулна:

23.2.1. энэ хуулийн 20.1.1-д заасан орлогын дүнд 2 хувиар;

23.2.2. энэ хуулийн 22.1.1-22.1.2-т заасан орлогын дүнд 5 хувиар;

23.2.3. энэ хуулийн 22.1.3-т заасан орлогын дүнд 40 хувиар.

23.3. Энэ хуулийн 21.2-т заасны дагуу тодорхойлсон хонин толгой тутамд дараахь хэмжээгээр албан татвар ногдуулна:

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

## 24 дүгээр зүйл. Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх

24.1. Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт 84000 төгрөгийн албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.

24.2. Малчин өрхийн гишүүний тоогоор тус бүр 20 хонийг тухайн өрхөд ногдуулах албан татвараас чөлөөлнө.

24.3. Малчин өрх өөрийн зардлаар худаг гаргаж ашиглалтад оруулсан бол түүнд зарцуулсан бөгөөд баримтаар нотлогдсон зардлыг энэ хуулийн 23.3-т зааснаар тухайн жилд ногдуулсан албан татвартай тэнцэх хэмжээний хөнгөлөлт үзүүлнэ.

24.4. Энэ хуулийн 24.3-т заасан хөнгөлөлтийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн үзүүлнэ.

24.5. Дор дурдсан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн буюу тариалсан Монгол Улсад оршин суугч хувь хүний зөвхөн тухайн үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлнө:

- 24.5.1. үр тариа;
- 24.5.2. төмс, хүнсний ногоо;
- 24.5.3. жимс, жимсгэнэ;
- 24.5.4. тэжээлийн ургамал.

24.6. Албан татвар төлөгчийн төрсөн буюу үрчилсэн хүүхэд гадаад, дотоодын их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид элсэн суралцаж байгаа бол түүний сургалтад төлсөн, баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.

24.7. Суралцаж байх хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн орлогоосоо албан татвар төлж, улмаар сургалтын төлбөр төлсөн ит, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид суралцагчийг энэ хуулийн 24.6-д заасан хөнгөлөлтөд хамааруулна.

## 25 дугаар зүйл. Гадаад улсад төлсөн албан татварт хөнгөлөлт үзүүлэх

25.1. Хувь хүнээс гадаад улсад төлсөн албан татварт хөнгөлөлт үзүүлэхдээ орлого ба

№	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж	Албан татварын хэмжээ /төгрөгөөр/
1	Нийслэл, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Төв аймаг	10
2	Архангай, Баянхонгор, Булган, Говь-Сүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий аймаг	7
3	Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг	5

хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай гэрээний дагуу шийдвэрлэнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Албан татвар ногдуулах, төсөвт төлөх, тайлагнах

#### 26 дугаар зүйл. Албан татвар ногдуулах, төсөвт төлөх

26.1. Энэ хуулийн 4.1.4-т заасан суутгагч албан татвар ногдуулахдаа дор дурдсан журмыг баримтална.

26.1.1. Энэ хуулийн 11 дүгээр зүйл, 12.2, 13.1.2-13.1.4, 15.1-д заасан орлогын дүнд мөн хуулийн 23.1-д заасан хувиар, 14.1.1-д заасан орлогын дүнд 23.2.1-д заасан хувиар, 8.1.6, 8.1.7-д заасан орлогын дүнд 23.2.2-т заасан хувиар, 8.1.8-д заасан орлогын дүнд 23.2.3-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

26.1.2. Энэ хуулийн 11.1.1-д заасан албан татварыг сар бүрийн эцэст ногдуулж, мөн хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийг хасч, холбогдох төсөвт шилжүүлэх;

26.1.3. Энэ хуулийн 11.1.2-11.1.5-д заасан албан татварыг тухай бүр нь ногдуулж, мөн хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийг хасч, холбогдох төсөвт шилжүүлэх;

26.1.4. Энэ хуулийн 11.1.6-д заасан албан татварыг уг орлогыг олгох тухай бүрт ногдуулж, мөн хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийг хасч, холбогдох төсөвт шилжүүлэх;

26.1.5. Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг албан татвар төлөгч нь энэ хуулийн 16.1.12, 24.6-д заасан хөнгөлөлт эдлэх бол татварын алба ажил олгогчтой албан татварын жилийн эцсийн тооцоо хийхдээ уг хөнгөлөлтийг албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлогоос хасч тооцох;

26.1.6. Банк, санхүүгийн байгууллага албан татвар төлөгчийн мөнгөн хадгаламжид хүү бодох бүрдээ энэ хуулийн 23.1-д заасан хувиар албан татвар ногдуулан суутгаж, тухай бүр холбогдох төсөвт шилжүүлэх.

26.2. Суутгагч энэ хуулийн 26.1.2-26.1.5-д зааснаар гүйцэтгэсэн ажиллагааг албан татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хийж баталгаажуулна.

26.3. Суутгагч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 26.1.6-д зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ.

#### 27 дугаар зүйл. Албан татварыг төсөвт төлөх

27.1. Албан татвар төлөгч албан татвар ногдуулах орлогоо энэ хуулийн дагуу өөрөө үнэн зөв тодорхойлж, дор дурдсан хугацаанд албан татварыг төсөвт төлнө.

27.1.1. Малчин өрх, мал бүхий этгээд албан татварыг хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

27.1.2. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татварыг энэ хуулийн 23.2.1-д заасан хувиар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор;

27.1.3. Түрээсийн орлогод ногдох албан татварыг энэ хуулийн 23.1-д заасан хувиар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор;

27.1.4. Энэ хуулийн 12 дугаар зүйл, 13.1.5, 14.1.2, 14.1.3-т заасан орлогод энэ хуулийн 23.1-д заасан хувиар тооцон улирал тутам албан татвар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор.

27.2. Албан татвар төлөгч энэ хуулийн 11.1.6, 12 дугаар зүйл, 13.1.1, 14.1.2, 14.1.3-т заасан орлого олж байгаа бол уг орлогод энэ хуулийн 23.1-д заасан хувиар, 8.1.6-д заасан орлого олж байгаа бол уг орлогод энэ хуулийн 23.2.2-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулан төлж, албан татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тухай бүр бүртгэн харьяа татварын албаар баталгаажуулах бөгөөд татварын жилийн эцэст уг албатай татварын тооцоо хийнэ.

27.3. Татварын алба малчин өрх, мал бүхий этгээдтэй тохиролцооноор албан татварыг урьдчилан төлүүлж болно.

27.4. Малчин өрх, мал бүхий этгээд албан татварыг мал нь байнга байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн холбогдох төсөвт төлнө.

#### 28 дугаар зүйл. Албан татварын тайланг хүргүүлэх хугацаа

28.1. Суутгагч нь энэ хуулийн 8.1.7, 8.1.8, 11 дүгээр зүйл, 13.1.2-13.1.4, 14.1.1, 15 дугаар зүйлд заасны дагуу суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор ессөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд ирүүлнэ.

28.2. Энэ хуулийн 8.1.6, 11.1.6, 12.1.1, 12.1.2, 12.2, 13.1.1, 13.1.5, 14.1.2, 14.1.3, 15 дугаар зүйлд заасан орлогын албан татвар төлсөн тайланг хувь хүний орлогын албан татвар тодорхойлох тайлангийн хуудсаар гаргаж, дараа оны 02 дугаар



сарын 15-ны өдрийн дотор татварын албанд хүргүүлнэ.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### Бусад

**29 дүгээр зүйл. Албан татвар төлөгчийг бүртгэх**

29.1. Үндэсний татварын алба албан татвар төлөгчийг дараахь журмаар бүртгэнэ:

29.1.1. албан татвар төлөгч нь тухайн нутаг дэвсгэрийнхээ татварын албанд бүртгүүлж, татвар төлөгчийн бүртгэлийн дугаар авах;

29.1.2. албан татвар төлөгч нь татвар төлөгчийн бүртгэлийн дугаар авахдаа бүртгэлийн маягт авч бөглөх;

29.1.3. татварын алба нь татвар төлөгчийн дугаар бүхий гэрчилгээг татвар төлөгчид олгох;

29.1.4. суутгагч нь иргэнд орлого олгох бүрдээ түүний татвар төлөгчийн дугаарыг

орлого олгосон тухай баримтад тэмдэглэж, иргэн бүрт олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээг тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж мэдэгдэх.

29.2. Энэ хуулийн 29.1.2, 29.1.3-т дурдсан маягт, гэрчилгээний загварыг Үндэсний татварын ерөнхий газар батална.

**30 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

30.1. Энэ хуулийг 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

30.2. Энэ хуулийн 13.1.3, 13.1.4-т заасан орлогод 2008 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн албан татвар ногдуулна.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын Их Хурал 1992 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Хүн амын орлогын албан татварын хуулийг хүчингүйд болсонд тооцугай.

хүний орлогын албан татварын хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс буюу 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Улсын Их Хурал 2006 оны 6 дугаар сарын 16-ны өдөр баталсан Хувь

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ /шинэчилсэн найруулга/

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Ерөнхий зүйл

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь аж ахуйн нэгжийн орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Хууль тогтоомж**

2.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /цаашид "албан татвар" гэх/-ын тухай хууль

тогтоомж нь Татварын ерөнхий хууль<sup>1</sup>, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1. Энэ хууль нь дор дурдсан аж ахуйн нэгжийн орлогод албан татвар ногдуулах харилцааг зохицуулна:

3.1.1. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар;

3.1.2. удирдах бйгууллага нь Монгол Улсад байрладаг гадаадын аж ахуйн нэгж;

<sup>1</sup> Татварын ерөнхий хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

3.1.3.Монгол Улсад орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж, тэдгээрийн төлөөний газар.

#### 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."гадаад улсад олсон орлого" гэж албан татвар төлөгчийн гадаад улсад олсон, энэ хуулийн 7.3-т заасан үйл ажиллагаа, хөрөнгө, хөрөнгө борлуулсны орлогыг;

4.1.2."бараа" гэж мөнгөн хөрөнгөнөөс бусад хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг;

4.1.3."үл хөдлөх эд хөрөнгө" гэж Иргэний хуулийн<sup>2</sup> 84.3, 86.2-т заасныг;

4.1.4."биет бус хөрөнгө" гэж биет шинж чанаргүй, харьцангуй урт хугацаанд ашиглагддаг, өөрийнхөө эзэмшигчид эрх, давуу эрх, онцгой эрх олгож байгаа эдийн бус хөрөнгийг;

4.1.5."аж ахуйн нэгж" гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийг;

4.1.6."суутгагч" гэж албан татвар төлөгчид олгосон орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээдийг;

4.1.7.гадаад валютын ханшийн зөрүүгийн орлого/алдагдал/гэж гадаад валют худалдах болон гадаад валютаар илэрхийлэгдсэн авлага, өглөгийн тооцоог барагдуулах зэрэг ажил, гүйлгээнээс үүссэн ханшийн зөрүүний ашиг /алдагдал/-ийг.

#### 5 дугаар зүйл. Албан татвар төлөгч

5.1.Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл тийм орлогогүй ч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий аж ахуйн нэгж нь албан татвар төлөгч байна.

5.2.Энэ хуулийн 5.1-т заасан албан татвар төлөгчийг Монгол Улсад байнга байрладаг, байрладаггүй албан татвар төлөгч гэж ангилна.

5.3.Монгол Улсад байнга байрладаг албан татвар төлөгчид дараахь аж ахуйн нэгж хамаарна:

5.3.1.Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж;

5.3.2.удирдах байгууллага нь Монгол Улсад байрладаг гадаадын аж ахуйн нэгж.

5.4.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид дараахь аж ахуйн нэгж хамаарна:

5.4.1.төлөөний газраараа дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж;

5.4.2.энэ хуулийн 5.4.1-д зааснаас бусад хэлбэрээр Монгол Улсад орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж.

5.5.Энэ хуулийн 5.4.1-т заасан аж ахуйн нэгжийн аж ахуйн үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчлэн явуулж байгаа дараахь нэгжийг төлөөний газарт хамааруулна:

5.5.1.салбар/цех, тасар/;

5.5.2.үйлдвэр;

5.5.3.худалдаа, үйлчилгээний газар;

5.5.4.газрын тос, байгалийн хийн цооног, түүнчлэн ашигт малтмал олборлож буй аливаа уурхай.

#### 6 дугаар зүйл. Харилцан хамаарал бүхий этгээд

6.1.Албан татвар төлөгчтэй дор дурдсан харилцаатай бол "харилцан хамаарал бүхий этгээд" гэж үзнэ:

6.1.1.энгийн хувьцааных нь 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг;

6.1.2.ногдол ашиг, ашгийн хуваарилалтынх нь 20 буюу түүнээс дээш хувийг авах эрхтэй;

6.1.3.аж ахуйн нэгжийн удирдлагын 20 буюу түүнээс дээш хувийг томилох эрхтэй, эсхүл үйл ажиллагааных нь бодлого чиглэлийг тодорхойлдог.

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ

##### Албан татвар ногдох орлого

#### 7 дугаар зүйл. Албан татвар ногдох орлого

7.1.Энэ хуулийн 5.3-д заасан албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсын нутаг дэвсгэрт болон гадаад улсад олсон орлогод албан татвар ногдоно.

7.2.Энэ хуулийн 5.4-т заасан албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж олсон орлогод албан татвар ногдоно.

7.3.Албан татвар төлөгчийн дараахь төрлийн орлогод албан татвар ногдоно:

7.3.1.үйл ажиллагааны орлого;

7.3.2.хөрөнгийн орлого;

7.3.3.хөрөнгө борлуулсны орлого.

<sup>2</sup> Иргэний хууль - Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

7.4. Албан татвар ногдох орлогын дүнг тодорхойлохдоо албан татвараас чөлөөлөгдсөн орлогыг хасч тооцно.

7.5. Бараа, ажил, үйлчилгээ солилцсон тохиолдолд албан татвар ногдох орлогыг тодорхойлохдоо харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдсэн ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнийг жишиг болгоно.

7.6. Гадаад валютаар олсон орлого, гарсан зардлыг төгрөгт шилжүүлэхдээ Монголбанкнаас тогтоосон тухайн өдрийн ханшийг үндэслэнэ.

## 8 дугаар зүйл. Үйл ажиллагааны орлого

8.1. Албан татвар төлөгчийн үйл ажиллагааны дараахь орлогод албан татвар ногдоно:

8.1.1. үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого;

8.1.2. эрх борлуулсны орлого;

8.1.3. хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого;

8.1.4. төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого;

8.1.5. эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэг худалдсан буюу төлбөртэй ашиглуулсан, эсхүл эротик тоглолт явуулсан үйлчилгээний орлого;

8.1.6. үнэ төлбөргүйгээр бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээний орлого;

8.1.7. биет бус хөрөнгө борлуулсны орлого;

8.1.8. техникийн, удирдлагын, зөвлөх болон бусад үйлчилгээний орлого;

8.1.9. гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй этгээдээс авсан хүү, анз /торгууль, алданги/, хохирлын нөхөн төлбөрийн орлого;

8.1.10. гадаад валютын ханшны зөрүүгийн бодит орлого;

8.1.11. энэ хуулийн 8.1.1-8.1.10-т заасантай адилтгах бусад орлого.

8.2. Эрх борлуулсны орлогод эрх бүхий байгууллагаас олгосон тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, эсхүл эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан хэлбэрээр бусдад төлбөртэй шилжүүлснээс олсон орлогыг хамааруулна.

8.3. Биет бус хөрөнгө борлуулсны орлогод энэ хуулийн 4.1.4-т заасан эдийн бус хөрөнгийг өмчлөх эрхээ бусдад хуульд заасан хэлбэрээр төлбөртэй шилжүүлснээс олсон орлогыг хамааруулна.

## 9 дүгээр зүйл. Хөрөнгийн орлого

9.1. Албан татвар төлөгчийн хөрөнгийн дараахь орлогод албан татвар ногдоно:

9.1.1. хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн орлого;

9.1.2. эрхийн шимтгэлийн орлого;

9.1.3. ногдол ашгийн орлого;

9.1.4. хүүгийн орлого.

9.2. Эрхийн шимтгэлийн орлогод дараахь төлбөр хамаарна:

9.2.1. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай<sup>3</sup> хуульд заасны дагуу зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг ашигласны төлбөр;

9.2.2. Патентын тухай<sup>4</sup> хуульд заасны дагуу шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар ашигласны төлбөр;

9.2.3. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай<sup>5</sup> хуульд заасны дагуу барааны тэмдэг ашигласны төлбөр;

9.2.4. Технологи дамжуулах тухай<sup>6</sup> хуульд заасны дагуу технологи дамжуулсны төлбөр;

9.2.5. үйлдвэр, худалдааны талаархи болон шинжлэх ухааны туршилттай холбогдсон мэдээллийг ашигласны төлбөр;

9.2.6. энэ хуулийн 9.2.1-9.2.5-д заасантай адилтгах бусад эрх ашигласны төлбөр.

9.3. Энэ хуулийн 9.1.3-т заасан ногдол ашгийн орлогод хувь нийлүүлсэн аж ахуйн нэгжээс ашиг хуваах, хувь хүртэх хэлбэрээр авсан мөнгөн болон мөнгөн бус орлого, түүний хүү хамаарна.

9.4. Энэ хуулийн 9.1.4-т заасан хүүгийн орлогод эзэлийн хүү, харилцах дансны үлдэгдлийн хүү, мөнгөн хадгаламжийн хүү, батлан даалт гаргасны төлбөр, өрийн бичиг/бонд/-ийн хүү зэрэг мөнгө ашиглуулсан болон ашиглуулах зориулалтаар хийгдсэн гүйлгээний үр дүнд албан татвар төлөгчид төлсөн төлбөр, үзүүлсэн хөнгөлөлт, урамшуулал хамаарна.

## 10 дугаар зүйл. Хөрөнгө борлуулсны орлого

10.1. Албан татвар төлөгчийн хөрөнгө борлуулсны дараахь орлогод албан татвар ногдоно:

10.1.1. үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;

10.1.2. хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого.

<sup>3</sup> Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Патентын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup> Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 19 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>6</sup> Технологи дамжуулах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

**11 дүгээр зүйл. Харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн бараа борлуулалт, ажил, үйлчилгээний албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох**

11.1. Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан этгээдүүд хоорондоо зах зээлийнхээс хямд буюу өндөр үнээр бараа борлуулсан буюу шилжүүлсэн, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн бол татварын алба нь харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдсэн ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын зах зээлийн үнийг жишиг болгон албан татвар ногдох орлогыг тодорхойлно.

11.2. Энэ хуулийн 7.5, 11.1-д заасан жишиг үнэ хэрэглэх аргачлалыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Албан татвар ногдох орлогоос хасагдах зардал

**12 дугаар зүйл. Албан татвар ногдох орлогоос хасагдах зардал**

12.1. Дараахь зардлыг албан татвар ногдох орлогоос хасч тооцсоны үндсэн дээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно:

12.1.1. түүхий эд, үндсэн болон туслах материал, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, уур, ус, эрчим хүч, түлш, шатахуун, сэлбэг хэрэгсэл, сав, баглаа боодлын зэрэг бүх төрлийн материалын зардал;

12.1.2. нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл хувь хүний орлогын албан татвар ногдуулан төлсөн цалин, хөдөлмөрийн үндсэн ба нэмэгдэл хөлс;

12.1.3. эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл;

12.1.4. ажиллагчдад олгосон шагнал, урамшуулал, байр, орон сууцны хөлс болон унаа, хоол, түлшний үнийн хөнгөлөлт;

12.1.5. үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэл;

12.1.6. урсгал засварын зардал;

12.1.7. зээлийн хүү;

12.1.8. гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит алдагдал;

12.1.9. бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс;

12.1.10. түрээсийн төлбөр;

12.1.11. санхүүгийн түрээсийн төлбөрийн хүү;

12.1.12. мэргэжлийн сонин, сэтгүүлийн захиалга;

12.1.13. заавал болон сайн дурын даатгалын хураамж;

12.1.14. төсөвт төлөхөөр

тайлагнасан онцгой, үл хөдлөх эд хөрөнгийн болон зарим бүтээгдхүүний үнийн өсөлтийн албан татвар, үндсэн хөрөнгөөс бусад импортын бараа, материал, түүхий эдийн гаалийн албан татвар, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, газар, байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамж;

12.1.15. хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршооны зээлийн эрсдэлийн санд, бусад үйл ажиллагаа эрхэлдэг хоршооны болзошгүй алдагдлын нөөц санд төвлөрүүлсэн хөрөнгө;

12.1.16. банк, банк бус санхүүгийн байгууллагын зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгө;

12.1.17. зар сурталчилгаа зардал;

12.1.18. ажиллагчдын сургалт, давтан сургалтын гүйцэтгэлээр нь тооцсон зардал;

12.1.19. албан томилолтын зардал;

12.1.20. үр бордоо, мал, амьтны тэжээл, эм тарилга, ургамал хамгааллын арга хэмжээнд зарцуулсан зардал;

12.1.21. тээврийн зардал;

12.1.22. бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйл худалдан авсан зардал;

12.1.23. хөдөлмөр хамгааллын

зардал;

12.1.24. холбоо, бичиг хэрэг,

цэвэрлэгээ, харуул хамгаалалтын зардал;

12.1.25. Гамшигаас хамгаалах тухай

хуулийн 4.1.10-т заасан гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгахад гарсан зардал;

12.1.26. бараа, материалын хэвийн

хорогдол;

12.1.27. Ашигт малтмалын тухай

хуулийн 38.1.8, 39.1.9-т заасны дагуу байгаль

орчныг нөхөн сэргээх зорилгоор төвлөрүүлсэн

мөнгөн хөрөнгө.

12.2. Энэ хуулийн 12.1.6-д заасан албан татвар ногдох орлогоос хасч тооцох зардал нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 2 хувь, бусад хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 5 хувиас хэтрэхээргүй байх бөгөөд үүнээс хэтрэсэн урсгал засварын зардлыг их засварын зардалд тооцно.

12.3. Энэ хуулийн 12.1.13-т заасан албан татвар ногдох орлогоос хасч тооцох сайн дурын даатгалын хураамжийн нийлбэр дүн нь тухайн аж ахуйн нэгжийн албан татвар ногдуулах орлогын 1% хувиас хэтрэхээргүй байна.

12.4. Энэ хуулийн 12.1.16-д заасан албан татвар ногдох орлогоос хасч тооцох зардалд банк, банк бус санхүүгийн байгууллагын хэвийн зээлийн үлдэгдэлд байгуулсан санд төвлөрүүлсэн хөрөнгө үл хамаарна.

<sup>1</sup> Гамшигаас хамгаалах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

12.5.Энэ хуулийн 12.1.19-д заасан албан татвар ногдох орлогоос хасч тооцох зардлыг гүйцэтгэлээр тооцох бөгөөд хэмжээ нь төрийн албан хаагчдын албан томилолтын зардлыг 2 дахин нэмэгдүүлснээс хэтрэхээргүй байна.

12.6.Энэ хуулийн 12.1.25-д заасан хохирлын хэмжээг холбогдох байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно.

12.7.Энэ хуулийн 12.1.26-д заасан хорогдлын хэмжээг Засгийн газар батална.

12.8.Дор дурдсан зардал албан татвар ногдох орлогоос үл хасагдана:

12.8.1.санхүүгийн түрээсийн төлбөр;

12.8.2.албан татвар төлөгчийн буруутай үйл ажиллагаатай холбогдон төлсөн торгууль, алданги, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлсөн төлбөр.

### 13 дугаар зүйл. Элэгдэл, хорогдлын шимтгэл тооцох

13.1.Албан татвар төлөгчийн 1 жилээс дээшхи хугацаанд ашиглах хөрөнгөд энэ хуулийн 12.1.5-д заасан элэгдэл, хорогдлын шимтгэл тооцно.

13.2.Үндсэн хөрөнгийг дор дурдсан хугацаагаар ашиглахаар тооцож, түүний элэгдэл, хорогдлын шимтгэлийг шулуун шугамын аргаар дараахь байдлаар байгуулна:

үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтцэд зарцуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг тэдгээр барилга, байгууламжийн ашиглагдах хугацаанд тогтмол хэмжээгээр тооцож жил бүр энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд оруулан тооцно.

13.6.Энэ хуулийн 13.2-т заасан ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн элэгдэл хорогдлын шимтгэл тооцох үнийг эдгээр зөвшөөрлийг эзэмших, шилжүүлэн авахтай холбогдон төлсөн үйлчилгээний хөлс, тусгай зөвшөөрлийн төлбөр, худалдан авсан үнийн дүнгээр тодорхойлно.

13.7.Албан татвар төлөгч өмчилж байгаа элэгдэл хорогдлын шимтгэл тооцох хөрөнгөө албан татвар ногдох орлого олох зорилгоор ашиглахаа зогсоовол уг хөрөнгийг үлдэгдэл өртөг, зах зээлийн үнийн аль их үнээр худалдан борлуулсан гэж үзэж албан татвар ногдуулна.

13.8.Санхүүгийн түрээсийн гэрээгээр түрээслэсэн хөрөнгийг, түрээслүүлэгч, түрээслэгч харилцан тохиролцож аль нэг талын санхүүгийн тайлан балансад бүртгэнэ.

13.9.Газар, бараа, материалын нөөцөд элэгдэл, хорогдлын шимтгэл тооцохгүй.

### 14 дүгээр зүйл. Албан татвар ногдох орлогоос хасч тооцох зардалд хамрах зээлийн хүү

	Үндсэн хөрөнгийн бүлэг	Ашиглах хугацаа /жилээр/
1	Барилга, байгууламж	40
2	Машин, механизм, техник, тоног төхөөрөмж	10
3	Компьютер, түүний эд анги, программ хангамж	3
4	Ашиглах хугацаа нь тодорхойгүй биет бус хөрөнгө	10
5	Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө /Үүнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна/	Хүчин төгөлдөр байх хугацаанд
6	Бусад үндсэн хөрөнгө	10

13.3.Энэ хуулийн 12.2-т заасан их засварын зардлыг уг хөрөнгийн үлдэгдэл өртөг дээр нэмж тооцох бөгөөд уг хөрөнгийг ашиглах үлдсэн хугацааны туршид элэгдэл хорогдлын шимтгэл тооцно.

13.4.Тухайн хөрөнгийн тодорхой нэг хэсэг нь албан татвар ногдох орлого олоход ашиглагдаж байвал элэгдэл, хорогдлын шимтгэлийг тухайн хэсэгт хувь тэнцүүлэн тооцож албан татвар ногдох орлогоос хасна.

13.5.Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийнхөө барьж байгуулсан

14.1.Энэ хуулийн 8.1.1-д заасан үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэх, түүнчлэн эд хөрөнгө худалдан авах зорилгоор авсан зээлийн хүүгийн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасч тооцно.

14.2.Албан татвар төлөгч ахуйн нэгжийг хяналтандаа байлгадаг Монгол Улсад байнга оршин суугч хувь хүнээс авсан зээлийн хүүгийн төлбөрийг тухайн албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлогоос хасч тооцохгүй бөгөөд энэ зардлыг зээл олгогос тухайн хувь хүний ногдол ашигт тооцох албан татвар ногдуулна.

14.3. Хөрөнгө оруулагчаас албан татвар төлөгчид сүүлд олгосон зээлийн дүн өмнө нь оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээнээс гурав дахинаас илүү гарсан бол ийнхүү илүү гарсан зээлд төлсөн хүүгийн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасч тооцохгүй бөгөөд түүнийг тухайн хөрөнгө оруулагчийн ногдол ашигт тооцож албан татвар ногдуулна.

14.4. Зээлийн хөрөнгөөр барилга байгууламж барих, тоног төхөөрөмж угсрах, суурилуулах хугацаанд уг зээлийн хүүд төлсөн төлбөрийг тухайн хөрөнгийн өртгийн хэсэгт оруулж тооцох бөгөөд түүнийг ашиглалтад оруулсан үеэс зээлийн хүүд төлсөн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасч тооцно.

## 15 дугаар зүйл. Хасагдах зардал тавигдах хязгаарлалт

15.1. Дараахь тохиолдолд зардлыг албан татвар ногдох орлогоос хасч тооцохгүй:

15.1.1. энэ хуульд заасан албан татвараас чөлөөлөгдөх орлого олоход гарсан зардал;

15.1.2. албан татвар төлөгчийн баримтаар нотлогдоогүй зардал;

15.1.3. энэ хуульд заасны дагуу суутган тооцох шаардлагатай боловч албан татвар суутгаагүй төлбөр.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

## 16 дугаар зүйл. Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

16.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг албан татвар төлөгчийн татварын жилийн албан татвар ногдуулах орлогод ногдуулна.

16.2. Энэ хуулийн 8.1.1, 8.1.6-8.1.11, 9.1.1 болон банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны хувьд 9.1.4-т заасан албан татвар ногдох орлогын нийт дүнгээс мөн хуулийн 12 дугаар зүйлд заасан зардлыг хасч албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

16.3. Дараахь орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо албан татвар ногдуулах тухайн орлого тус бүрийн нийт дүнгээр тооцно:

16.3.1. ногдол ашгийн орлого;

16.3.2. эрхийн шимтгэлийн орлого;

16.3.3. үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;

16.3.4. хүүгийн орлого;

16.3.5. эрх борлуулсны орлого;

16.3.6. эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэг худалдсан буюу төлбөртэй ашиглуулсан, түүнчлэн эротик тоглолт явуулсан үйлчилгээний орлого;

16.4. Албан татвар төлөгчийн хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж татан буугдсан бол ногдол ашгийн албан татвар ногдуулах орлогыг албан татвар төлөгчийн эзэмшиж байгаа хувьцаа болон хувь нийлүүлсэн хөрөнгөд хувь тэнцүүлэн хуваарилсан орлогын дүнгээс уг хувьцаа болон хөрөнгийг анх худалдан авсан үнийг хасч тодорхойлно.

16.5. Банк, банк бус санхүүгийн байгууллагын зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах болон хадгаламж зээлийн хоршооны зээлийн эрсдлийн сангийн албан татвар ногдох орлогоос хасагдсан зээлийг эргүүлэн төлсөн бол ийнхүү төлөгдсөн зээлийн дүнд энэ хуульд заасны дагуу албан татвар ногдуулна.

16.6. Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлогоос уг орлогыг олохтой холбогдон гарсан баримтаар нотлогдох зардал, хонжворт олгосон мөнгөн хөрөнгө болон барааны үнийг хасч албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

16.7. Даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн даатгалын үйл ажиллагааны нийт орлогоос тухайн жилд байгуулсан нөөцийн сан болон ажиллагааны зардлыг хасч албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

16.8. Хувьцаа, үнэт цаас борлуулсан тохиолдолд албан татвар ногдуулах орлогыг тэдгээрийг худалдсан үнээс худалдан авсан үнийг хасч тодорхойлно.

16.9. Хөдлөх эд хөрөнгө борлуулсан тохиолдолд албан татвар ногдуулах орлогыг уг хөрөнгийн борлуулалтын орлогоос хөрөнгийн үлдэгдэл өртгийг хасч тодорхойлно.

16.10. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч төлөөний газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулдаг бол түүний албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо дараахь зардлыг хасагдах зардалд тооцохгүй:

16.10.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна гарсан зардал;

16.10.2. тухайн орлогыг олоход хамааралгүй, удирдлагын болон захиргааны зардал.

## ТАВДУГААР БҮЛЭГ

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Албан татварын хувь, хэмжээ

### Албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх

**17 дугаар зүйл. Албан татварын хувь, хэмжээ**

17.1. Энэ хуулийн 16.2, 16.8, 16.9-д зааснаар тодорхойлоход 0-3,0 тэрбум төгрөгний албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 3,0 тэрбум төгрөгнөөс дээш албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 300,0 сая төгрөг дээр 3,0 тэрбум төгрөгнөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж албан татвар ногдуулна.

17.2. Албан татвар төлөгчийн дараахь орлогод дор дурдсан хувиар албан татвар ногдуулна:

17.2.1. ногдол ашгийн орлогод 10 хувиар;

17.2.2. эрхийн шимтгэлийн орлогод 10 хувиар;

17.2.3. энэ хуулийн 16.6-д зааснаар тодорхойлсон төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлогод 40 хувиар;

17.2.4. эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэг худалдсан буюу төлбөртэй ашиглуулсан, түүнчлэн эротик тоглолт явуулсан үйлчилгээний орлогод 40 хувиар;

17.2.5. үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод 2 хувиар;

17.2.6. хүүгийн орлогод 10 хувиар;

17.2.7. эрх борлуулсны орлогод 30 хувиар;

17.2.8. гадаадын аж ахуйн нэгжийн төлөөний газар өөрт ногдох ашгаасаа гадаадад шилжүүлбэл шилжүүлсэн ашгийн 20 хувиар;

17.2.9. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч Монгол Улсад олсон дараахь орлогод 20 хувиар:

а/Монгол Улсад бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс авсан ногдол ашгийн орлого;

б/зээлийн хүүгийн болон батлан даалт гаргасны төлбөр;

в/эрхийн шимтгэлийн орлого, санхүүгийн түрээсийн хүүгийн орлого, удирдлагын зардалд төлсөн төлбөр, түрээсийн төлбөр, биет болон биет бус хөрөнгө ашиглуулсны орлого;

г/Монгол Улсын нутаг дэвсгэр дээр борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлого.

**18 дугаар зүйл. Албан татвараас чөлөөлөх**

18.1. Албан татвар төлөгчийн дараахь орлогыг албан татвараас чөлөөлнө:

18.1.1. Засгийн газрын өрийн бичгийн/бонд/ хүү;

18.1.2. газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон, энэ хуулийн 17.1, 17.2.1-т заасан орлого;

18.1.3. гишүүдийнхээ бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааны зуучлалын үнийн зөрүүгээс олсон хоршооны орлого.

18.2. Энэ хуулийн 18.1.2-т заасан албан татвар төлөгч өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон бөгөөд албан татвараас чөлөөлөгдсөн орлогыг гадаадад шилжүүлэх тохиолдолд мөн хуулийн 17.2.8-д заасан хувиар албан татвараас чөлөөлөгдөнө.

**19 дүгээр зүйл. Албан татвараас хөнгөлөх**

19.1. Дор дурдсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн буюу тариалсан аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар хөнгөлнө:

19.1.1. үр тариа, төмс, хүнсний ногоо;

19.1.2. сүү;

19.1.3. жимс жимсгэнэ;

19.1.4. тэжээлийн ургамал.

19.2. Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хөрөнгө оруулсан бол уг хөрөнгө оруулалтын 10 хувьтай тэнцэх албан татварын хөнгөлөлтийг үзүүлнэ.

19.3. Энэ хуулийн 19.2-т заасан хөнгөлөлтийг Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт үйлдвэрлэл, үйлчилгээг шинээр бий болгох, эсхүл эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх, шинэчлэх зорилгоор элэгдэл байгуулах үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалтад үзүүлнэ.

19.4. Аж ахуйн үндсэн үйл ажиллагааны орлогоос бусад орлого олох зорилгоор хөрөнгө худалдан авсан бол энэ хуулийн 19.3-т заасан хөнгөлөлт үзүүлэхгүй.

19.5. Энэ хуулийн 19.2-т заасан хөнгөлөлтийн дүн нь тухайн татварын жилд энэ

хуулийн 17.1-д заасны дагуу ногдуулсан албан татварын дүнгээс их байвал илүү гарсан хэсгийг ашигтай ажилласан дараагийн 3 жилд шилжүүлэн хөнгөлнө.

19.6. Энэ хуулийн 19.1, 19.2-т заасан хөнгөлөлтийг тухайн аж ахуйн нэгж үндсэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн өдрөөс эхлэн тооцно.

19.7. Энэ хуулийн 19.2-т заасан тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг Засгийн газар батална.

19.8. 50-иас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эзэлж байгаа хувь хэмжээгээр тооцон албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.

19.9. Аж ахуйн нэгжийн гадаад улсад төлсөн албан татварт хөнгөлөлт үзүүлэхдээ орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай гэрээний дагуу шийдвэрлэнэ.

## 20 дугаар зүйл. Татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох

20.1. Албан татвар ногдох орлогоос энэ хуулийн 15 дугаар зүйлд зааснаас бусад мөн хуулийн 12 дугаар зүйлд заасан нийт зардлыг хасч илүү гарсан хэсгийг нь татварын тайлангаар гарсан алдагдал гэнэ.

20.2. Энэ хуулийн 20.1-д заасан алдагдлыг уг алдагдал гарсан татварын жилийн дараахь дараалсан 2 жилийн албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно.

20.3. Энэ хуулийн 20.2-т заасны дагуу албан татвар ногдуулах орлогоос жил бүр хасагдах алдагдлын хэмжээ нь тухайн жилийн албан татвар ногдуулах орлогын дүнгийн 50 хувиас хэтрэхээргүй байна.

20.4. Энэ хуулийн 20.1-т заасан алдагдалд 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх татварын жилийн татварын тайлангаар гарсан алдагдал хамаарахгүй.

## ДОЛООДУГААР БҮЛЭГ

### Албан татвар ногдуулах, төсөвт төлөх, тайлагнах

#### 21 дүгээр зүйл. Албан татвар төлөх, тайлагнах

21.1. Албан татвар төлөгч нь нягтлан бодох бүртгэлийн акруал сууриар гаргасан улирал,

жилийн татварын тайланг үндэслэн жилийн эхнээс өссөн дүнгээр орлого болон төлөх албан татвараа өөрөө үнэн зөв тодорхойлж төсөвт төлнө.

21.2. "Татварын жил" гэдэгт орлого олж, холбогдох зардал гарсан хуанлийн жилийг ойлгоно.

21.3. Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хуваарийг үндэслэн харьяалах татварын алба тухайн татварын жилд төлөх албан татварын сар, улирлын хуваарийг албан татвар төлөгчид хүргүүлнэ.

21.4. Албан татвар төлөгч энэ хуулийн 21.3-т зааснаар хүргүүлсэн хуваарийн дагуу сар бүрийн 25-ны дотор албан татварыг урьдчилан төлж, татвар төлөлтийн улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, албан татварын жилийн эцсийн тооцоо хийнэ.

21.5. Энэ хуулийн 17.2.1-17.2.3, 17.2.7-17.2.9-д заасан орлогод ногдох албан татварыг мөн хуулийн 4.1.6-д заасан суутгагч ногдуулан суутган авч, ажлын 7 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ.

21.6. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татварыг суутгагч ногдуулан суутган авч, уг хөрөнгийг борлуулснаас хойш ажлын 10 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ.

21.7. Суутгагч нь энэ хуулийн 21.5, 21.6-д зааснаар суутгасан албан татварын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор улирал бүр өссөн дүнгээр, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор гаргаж, харьяалах татварын албанд тушаана.

21.8. Төр нь өмчдөө ногдох ашиг болон хувьцааны ногдол ашгийг бүрэн буюу хэсэгчлэн төсөвт дайчлах эрхтэй бөгөөд хэмжээг нь Засгийн газар тухай бүр тогтооно.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### Бусад

#### 22 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

22.1. Энэ хууль 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын Их Хурал 1992 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийг хүчингүй болсонд тооцугай.

ажуйн нэгжийн орлогын албан татварын хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс буюу 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Улсын Их Хурал 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан Аж

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

### ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын Их Хурал 1998 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр баталсан Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

ажуйн нэгжийн орлогын албан татварын хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс буюу 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Улсын Их Хурал 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан Аж

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

### Үнэлгээ хийх эргэчлэл, журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 12.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам"-ыг 1 дүгээр, "Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Аж ахуйн нэгж, байгууллага болон орон нутагт тохиолдож болзошгүй гамшгийн эмзэг

байдал, эрсдэлийн үнэлгээг энэ журмын дагуу хийж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд С.Отгонбаярт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД С.ОТГОНБАЯР

*Засгийн газрын 2006 оны 176 дугаар тогтоолын 1 дүгээр хэсрэлт*

### ГАМШГИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо (цаашид "нутаг дэвсгэрийн нэгж" гэх) болон аж ахуйн нэгж, байгууллагад тохиолдож болзошгүй гамшгийн аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний үндэс болох гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ (цаашид "үнэлгээ" гэх)-ний ажлыг гүйцэтгэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь харъяалал, өмчийн төрөл, хэлбэрээс үл шалтгаалан гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийлгэнэ.

1.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үнэлгээ хийх ажлын хэсгийг томилоно. Үнэлгээний ажлын материалгүй эх хувиар нь хадгална. Ажлын хэсэг нь үнэлгээний тайланг 2 хувь үйлдэж онцгой байдлын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага болон үнэлгээ хийлгэгч аж ахуйн нэгж, байгууллагад өгнө.

1.4. Тухайн нутаг дэвсгэрийн нэгж, аж ахуйн нэгж, байгууллага гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн эсэхэд онцгой байдлын асуудал ээрхэлсэн орон нутгийн байгууллага, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хяналт тавина.

1.5. Үнэлгээ хийлгээгүй үйл ажиллагаа явуулсан буюу үнэлгээ хийсний үндсэн дээр гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлээгүйн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, эд хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

1.6. Ажлын хэсэг нь үнэлгээг хангалтгүй хийсний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, эд хөрөнгөд хохирол учирсан бол зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

## Хоёр. Үнэлгээ хийх ажлын хэсгийн эрх, үүрэг

2. Ажлын хэсэг нь бүс нутгийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, гамшгийн аюул, ослын нөхцөл байдлыг харгалзан үнэлгээ хийнэ. Ажлын хэсэг холбогдох албад, байгууллагын мэргэжилтнээс бүрдэнэ.

2.1. Үнэлгээ хийх ажлын хэсэг нь дор дурдсан эрхтэй байна:

2.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт орших аж ахуйн нэгж, байгууллагад гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх;

2.1.2. үнэлгээний ажилд шаардлагатай баримт бичгийг үнэлгээ хийлгэж байгаа этгээдээс гаргуулан авах;

2.1.3. урьд нь хийгдсэн судалгаа, шинжилгээний дүгнэлтийг ашиглах;

2.1.4. үнэлгээний тайланд хийсэн шүүмжийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах.

## 2.2. Үнэлгээ хийх ажлын хэсгийн үүрэг

2.2.1. үнэлгээний тайлан гаргах

2.2.2. үнэлгээний ажлын тайланг холбогдох бусад баримт бичгийн хамт үнэлгээ хийлгэсэн нутаг дэвсгэрийн нэгж, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэх;

2.2.3. үнэлгээний эцсийн үр дүнгийн талаар хариуцлага хүлээх;

2.2.4. тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, техник, технологи, бизнесийн мэдээллийн нууцыг хадгалах.

## Гурав. Үнэлгээ хийлгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын бүрэн эрх, үүрэг

3.1. Үнэлгээ хийлгэгч аж ахуйн нэгж, байгууллага нь дор дурдсан бүрэн эрхтэй байна:

3.1.1. тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, техник, технологи, бизнестэй холбоотой зарим мэдээллийг нууцлахыг үнэлгээний ажлын хэсгээс шаардах;

3.1.2. үнэлгээ хийлгэх хүсэлтээ онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргах;

3.1.3. гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийлгэх;

3.1.4. үнэлгээ хийхэд шаардлагатай баримт бичгийг ажлын хэсэгт гаргаж өгөх.

## Дөрөв. Үнэлгээ хийх

4.1. Үнэлгээ хийх ажлын хэсэг нь үнэлгээг гамшгийн аюул, осол тус бүрийн онцлогт тохирсон аргачлалын дагуу хийнэ.

4.2. Үнэлгээ хийхдээ аюул осол, тохиолдож болзошгүй шалтгаан, түүний хамрах хүрээ, нутаг дэвсгэр, далайц, хүндрэл, нөлөөлж болох байгаль, цаг уурын нөхцөл, тохиолдох давтамжийн магадлал, сүйтгэл учруулах механизм, сүйтгэлд хамгийн их өртөгдөх зүйл болон үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн чанарын баталгаа, аюулгүй ажиллагааны системийн удирдлага, зохион байгуулалт, гамшгаас учрах нийгэм, эдийн засгийн болзошгүй үр дагавар зэргийг цогцоор нь авч үзнэ.

4.3. Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээнд хүн ам, эд хөрөнгийг авран хамгаалах асуудалтай хамт эдийн засаг, нийгэмд учруулах сөрөг үр дагаврыг бууруулах менежментийг тусгана.

4.4. Үнэлгээ хийхэд тухайн нутаг дэвсгэрийн байр зүйн зураг болон бусад шаардлагатай материалыг ашиглана.

4.5. Ажлын хэсэг нь үнэлгээ хийх гэж байгаа нутаг дэвсгэрийн нэгж, аж ахуйн нэгж, байгууллагатай нарийвчлан танилцах бөгөөд судалгааны ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэж болно. Үнэлгээ хийсний дараа тайлан гаргана.

4.6. Тайланд дараахь зүйлийг тусгасан байна:

- үнэлгээ хийлгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны талаархи товч тодорхойлолт;

- гамшгийн аюулын судалгаа, шинжилгээ;

- эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ;

- үнэлгээнд хийх дүгнэлт;

- эмзэг байдлыг бууруулах талаархи зөвлөмж.

## Тав. Үнэлгээ хийлгэх үйл ажиллагааны санхүүжилт

5.1. Тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга нь гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах хөрөнгийг гамшгаас хамгаалах арга хэмжээний төсөвт тусгана.

5.2. Хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага нь үнэлгээ хийлгэхэд шаардагдах хөрөнгийг өөрөө хариуцна.

5.3. Үнэлгээний зардалд ажлын хэсгийн гишүүдэд олгох урамшуулал, томилолт, тээврийн болон шуудан холбоо, байр, бичиг хэрэг, судалгаа, шинжилгээний зардлыг тусгана.

### Зэсгийн газрын 2006 оны 176 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## ГАМШГИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал нь (цаашид "аргачлал" гэнэ) үнэлгээний ажлын явцад заавал мөрдөх ерөнхий зарчимтай байна.

1.2. Аргачлал нь дараахь шаардлагыг хангасан байна:

-тухайн гамшгийн эмзэг байдал, эрсдэлийг бодитой үнэлэн, учирч болох хохирлыг таамаглах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломж олгох;

-гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн хувьсамтгай шинжийг тусгаж, болзошгүй гамшгаас хамгаалах арга хэмжээ авахад шаардлагатай бодит үнэлгээ хийх нөхцөл бүрдүүлэх;

-шинжлэх ухааны үндэслэлтэй, гамшгийн өнгөрсөн сургамжид тулгуурлан боловсронгуй болж байх.

### Хоёр. Үнэлгээ хийх ерөнхий аргачлал

2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт:

- ган, зуд;
- хүчтэй цасан болон шороон шуурга;
- ой, хээрийн болон объектын гал түймэр;
- хүний болон малын гоц халдварт өвчин;
- үйлдвэр-зам тээврийн осол;
- газар хөдлөлт;
- үер усны аюул;
- гол, нуурын усанд осолдох, мөс цөмрөх тохиолдол;
- хот, суурин дахь хөдлөлт;
- болзошгүй террорист үйлдэл зэрэг

гамшгаас үүсэх магадлалыг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд үнэлэн, аюулын зэрэглэл тогтооно. Аж ахуйн нэгж, байгууллагын гамшигт өртөх магадлалыг энэхүү хавсралтаар баталсан аргачлалын дагуу тогтооно.

2.2. Энэхүү аргачлалын дагуу 2.1-д дурдсан гамшгийн төрөл тус бүрээр гамшгийн өмнөх,

гамшгийн дараахь гэсэн үнэлгээг ялгавартайгаар хийнэ.

2.3. Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийг үнэлэхдээ:

- статистик арга;
- ажиглалт хийх арга;
- ярилцлага хийх арга;
- таамаглал дэвшүүлэх арга;
- хагас зохион байгуулалтын арга;
- зэрэглэл тогтоох арга;
- загварчлалын арга;
- ижил төсөөлөл харьцуулалтын арга;
- системийн анализын арга гэх мэт судалгаа, шинжилгээний олон аргыг хэрэглэнэ.

### Гурав. Гамшгийн өмнөх үнэлгээний аргачлал

3.1. Үнэлгээг хийхдээ дараахь ерөнхий зарчмыг баримтална:

- эрсдэл бий болгох аюулт үзэгдлийг тогтоож, аюулыг үнэлэн, аюулын зэрэглэл тогтоож, болзошгүй хор хөнөөлийн дүн шинжилгээ хийнэ;
- тухайн эрсдэлтэй холбоотой эмзэг байдлын үнэлгээ хийнэ;
- эрсдэлийг бууруулахад чиглэсэн гамшигтай тэмцэх чадавхийн үнэлгээ хийнэ;
- аюулын үнэлгээ, эмзэг байдлын үнэлгээ, гамшигтай тэмцэх чадавхийн үнэлгээнд үндэслэн эрсдэлийн үнэлгээ хийнэ.

3.2. Аюулын үнэлгээ:

Тухайн нутаг дэвсгэрт төхиолдож болзошгүй аюулт үзэгдлийг тогтооно. Аюулт үзэгдэл тус бүрээр аюулыг үнэлнэ. Ингэснээр аюулт үзэгдлийг эрсдэлийн түвшингээр нь зэрэглэн ангилж, эрсдэлийг бууруулах хүзилбэруудыг гаргах боломж олгоно. Аюулт үзэгдэл тус бүрт:

- шияж чанар;
- хэр ноцтой;
- тохиолдох давтамж;
- учруулж болзошгүй эхирэл;
- тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн аюулыг гэтлэн давах чадвар;

-тухайн аюулт үзэгдлийн талаар урьд нь хийсэн судалгаа, бүртгэл байгаа зэргийг тогтооно.

### 3.3. Эмзэг байдлын үнэлгээ:

Дараахь үзүүлэлтээр гамшгийн төрөл тус бүрээр эмзэг байдлын үнэлгээ хийнэ:

- гамшигт өртөх магадлал ихтэй хүн ам;
- хүн амын бүтэц, тархалт, суурьшил;
- дэд бүтэц, түүний сул тал;
- барилгын стандарт, ашиглалтын хугацаа;
- эдийн засгийн чадавхи;
- шашин шүтлэг, уламжлалт ёс заншил;
- байгаль орчин, түүний өртөмтгий чанар зэргийг тогтооно. Бусад шаардлагатай нэмэлт мэдээллийг цуглуулан нэгтгэж, дүн шинжилгээ хийж замаар эмзэг байдлын ерөнхий мэдээлэл болон газрын зураг боловсруулна.

### 3.4. Гамшигтай тэмцэх чадавхийн үнэлгээ:

Гамшигтай тэмцэх чадавхийн үнэлгээг гамшгийн төрөл бүрээр хийнэ. Үнэлгээгээр:

- удирдлагын тогтолцоо;
- гамшгийн талаархи хууль тогтоомж;
- гамшгийн бэлэн байдал;
- гамшгаас хамгаалах төлөвлөлт;
- гамшгийн аюулыг бууруулах цогц арга хэмжээ;
- зарлан мэдээлэл, прогнозчиллын систем;
- сурталчилгаа, мэдээллийн систем, түүний үйл ажиллагаа;
- нөөц хөрөнгө;
- хүн амын идэвхи оролцоо;
- хүн амын дунд хийгдсэн сургалт, түүний түвшин зэргийг үнэлнэ.

### 3.5. Эрсдэлийн үнэлгээ

Аюулт үзэгдлийн төрөл бүрээр хийсэн аюулын, эмзэг байдлын, чадавхийн үнэлгээг ашиглан тухайн аюулт үзэгдлийн эрсдэлийг үнэлнэ. Эрсдэлийн үнэлгээгээр болзошгүй аюулаас үүсч болох хохирлын магадлалыг тогтооно.

Эрсдэлийн үнэлгээгээр дараахь магадлалыг тогтооно:

- эрсдэлийг үүсгэж болох хөнөөлт хүчин зүйл тухайн нутаг дэвсгэрт үүсэх магадлал;
- хүн ам, байгаль орчинд эрсдэл учруулах тодорхой нөхцөл бүрэлдэх магадлал;
- үүссэн эрсдэлээс хүн ам, байгаль орчинд хохирол учрах магадлал;

-учирч болох эрсдэлийн түвшин буюу хүн ам, хүрээлэн байгаа орчинд эрсдэл учрах магадлал зэрэг болно.

### 3.6. Эрсдэлийн тоон утгыг

$$R = K \frac{D \times V}{Z}$$

гэсэн ерөнхий томъёогоор илэрхийлж болно. Үүнд:

- $R$  – үнэлж байгаа эрсдэлийн хэмжээ,
- $K$  – туршлагын үндсэн дээр тогтоогдсон гамшгийн коэффициент,
- $D$  – аюулын хэмжээ,
- $V$  – эмзэг байдлын хэмжээ,
- $Z$  –гамшигтай тэмцэх чадавхи.

### Дөрөв. Гамшгийн дараахь үнэлгээний аргачлал

4.1. Гамшгийн дараахь үнэлгээний аргачлал нь гамшгийн хор уршиг, гамшиг дахин үүсч болох магадлалыг үнэлнэ.

4.2. Гамшгийн улмаас үүссэн шууд хохирлыг үнэлэхдээ:

- амь үрэгдсэн, шархдаж гэмтсэн хүний тоо;
- эвдэрч сүйдсэн эд хөрөнгө;
- байгаль орчинд учирсан хохирол;
- нийгэм, эдийн засагт учирсан хохирол зэргийг шинжилж үнэлнэ.

4.3. Нийт хохирлын хэмжээг тодорхойлохдоо

$$L = \sum_{i=1}^n V_i \times k_i$$

гэсэн томъёо ашиглаж болно. Үүнд:

$L$  –хүн болон эд хөрөнгөд учирсан нийт хохирол,  $n$ –аюулд өртсөн элементийн тоо (хүн, эд хөрөнгө).

$V_i$  –тухайн гамшигт харгалзсан эмзэг байдал,

$k_i$  –тухайн элементийн өртөг (хүн үрэгдсэн буюу объект бүрэн нурсан үед).

4.4. Гамшгийн дараахь анхан шатны үнэлгээгээр нөхцөл байдлыг үнэлж, хор уршиг: нэн даруй арилгах үйл ажиллагаанд шаардагдах хэрэгцээ, тусламжийн түвшинг тодорхойлно. Үнэлгээгээр доорхи зүйлийг тогтооно:

- тухайн гамшгийн төрөл, онцлог шинж чанарыг тогтоох;

-гамшгийн хор хохирлыг тогтоох;  
-хүн амын нэрвэгдэлтийн байдлыг үнэлэх;

-хор уршгийг арилгах тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн чадавхийг тогтоож, тусламжийн үйл ажиллагааг хэрхэн явуулах талаархи мэдээллээр шийдвэр гаргагчдыг хангах;

-гадаад орон, олон улсын байгууллагаас тусламж авах эсэхийг тогтоож, шаардлагатай тусламжийн хэмжээг тодорхойлох;

-тусламжийг хүргэх арга зам, хэрэгслийг тогтоох;

-хэрэгжүүлж болох аврах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны чиглэл зэрэг болно.

4.5. Гамшгийн дараахь сэргээн засварлах, сэргээн босгох үеийн үнэлгээ нь:

-нэрвэгдсэн хүмүүст нэн тэргүүнд тулгамдсан асуудал;

-гамшгийн дараахь тусламжийн асуудлаар шийдвэр гаргагчдад хүргэх мэдээлэл;

-яаралтай тусламж болон сэргээн босгох үйл ажиллагаанд үндэсний болон олон улсын байгууллагаас авах шаардлагатай хүмүүнлэгийн тусламжийн хэмжээ;

-авч байгаа яаралтай тусламж, сэргээн засварлах арга хэмжээний явц, үр өгөөж зэргийг тус тус тогтооно.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 8.7, Иргэний бүртгэлийн тухай хуулийн 23.5-ыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын үндэсний гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 109 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Д.ОДБАЯР

Засгийн газрын 2006 оны 184 дүгээр тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ГАДААД ПАСПОРТ ОЛГОХ, ЭЗЭМШИХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг Үндэслэл

1.1. Монгол Улсын үндэсний гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эзэмших, хадгалахад энэхүү журмыг баримтална.

1.2. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

### Хоёр. Үндэсний гадаад паспорт

2.1. Үндэсний гадаад паспорт нь дипломат, албан, энгийн төрөлтэй байна.

2.2. Үндэсний гадаад паспорт нь төрийн өмч байна.

2.3. Үндэсний гадаад паспорт, хүүхдийн хавсралт үнэмлэхийн загвар, нууцлалын үзүүлэлтийг гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.4. Үндэсний гадаад паспорт нь Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага (ИКАО)-ын стандартад нийцсэн байна.

2.5. Үндэсний гадаад паспортын үнэ, бичилтийн төлбөр, үйлчилгээний хөлсний хэмжээг санхүү, гадаад хэрэг болон хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

### Гурав. Үндэсний гадаад паспортын зориулалт

3.1. Дипломат, албан паспортыг энэхүү журмын 5-д заасан Монгол Улсын иргэнд, энгийн паспортыг гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах Монгол Улсын иргэнд олгоно.

3.2. Үндэсний гадаад паспорт нь 5 хүртэл жилийн хугацаанд дэлхийн бүх улсад зорчиход хүчинтэй байх бөгөөд шаардлагатай тохиолдолд хугацааг нь сунгаж болно.

3.3. Насанд хүрээгүй хүүхдэд үндэсний гадаад паспорт олгож болно.

3.4. Насанд хүрээгүй хүүхдэд үндэсний гадаад паспорт олгоогүй бол эцэг (эх)-ийн буюу

асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үндэсний гадаад паспортад хавсаргах хүүхдийн хавсралт үнэмлэх олгоно.

Тав хүртэлх насны хүүхдийн хувьд түүний гэрэл зургийг эцэг (эх) буюу асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үндэсний гадаад паспортын тусгай тэмдэглэлийн хуудсанд нааж, овог нэрийг бичиж баталгаажуулна.

3.5. Үндэсний гадаад паспорт эзэмшихэд төрөл, тоонд хязгаар тогтоохгүй.

## **Дөрөв. Үндэсний гадаад паспорт олгох байгууллага**

4.1. Үндэсний гадаад паспортыг Гадаад хэргийн яам, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн алба, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн болон Консулын газар олгоно.

4.2. Гадаад хэргийн яам:

4.2.1. дипломат, албан паспорт олгох, хугацааг нь сунгах, хүчингүй болгох ажлыг эрхэлж, нэгдсэн бүртгэл хөтлөн мэдээллийн сан бүрдүүлж, ерөнхий хяналт тавина;

4.2.2. дипломат паспортад гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүний эзгүйд Гадаад хэргийн дэд сайд, сайд болон дэд сайдын эзгүйд Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, албан паспортад Гадаад хэргийн яамны Консулын газрын захирал гарын үсэг зурж баталгаажуулна;

4.2.3. дипломат, албан паспортыг мэдүүлэг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор олгоно.

4.3. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв:

4.3.1. энгийн паспорт, хүүхдийн хавсралт үнэмлэх олгох, хугацааг нь сунгах, хүчингүй болгох ажлыг эрхэлж, нэгдсэн бүртгэл хөтлөн мэдээллийн сан бүрдүүлж, ерөнхий хяналт тавина;

4.3.2. энгийн паспорт, хүүхдийн хавсралт үнэмлэхэд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга /дэд дарга/, гадаад паспортын хэлтсийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна;

4.3.3. энгийн паспортыг өргөдөл хүлээн авснаас хойш ажлын арав хоногийн дотор олгоно.

4.4. Аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн алба:

4.4.1. энгийн паспорт, хүүхдийн хавсралт үнэмлэх олгох, хугацааг нь сунгах, хүчингүй болгох ажлыг орон нутагтаа эрхэлж бүртгэл хөтлөн хяналт тавина;

4.4.2. энгийн паспорт, хүүхдийн хавсралт үнэмлэхэд аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэлийн албаны дарга, түүний эзгүйд тухайн аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Хууль зүйн хэлтсийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна;

4.4.3. Сэлэнгэ аймгийн Мандал сум, нийслэлийн Багахангай, Налайх, Багануур дүүрэгт энгийн паспортын хугацааг сунгах, хүүхдийн хавсралт үнэмлэх олгоход тухайн сум, дүүргийн Засаг дарга, Тамгын газрын дарга гарын үсэг зурж баталгаажуулна;

4.4.4. энгийн паспортыг өргөдөл хүлээн авснаас хойш гуч хоногийн дотор Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд хүргүүлж бичилт хийлгэн баталгаажуулж олгоно.

4.5. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн болон Консулын газар:

4.5.1. шаардлагатай тохиолдолд үндэсний гадаад паспорт олгож, мөн дипломат, албан паспортын хугацааг Гадаад хэргийн яамны зөвшөөрлөөр, энгийн паспортын хугацааг иргэний хүсэлтээр сунгаж болно;

4.5.2. Үндэсний гадаад паспортад хилийн чанадад дипломат төлөөлөгчийн болон консулын газрын тэргүүн, түүний эзгүйд консулын хэлтсийн дарга, консул, эсхүл консулын асуудал хариуцсан дипломат ажилтан гарын үсэг зурж баталгаажуулна;

4.5.3. энгийн паспортыг өргөдөл хүлээн авснаас хойш ажлын гуч хоногийн дотор Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд хүргүүлж бичилт хийлгэн баталгаажуулж олгоно.

## **Тав. Дипломат, албан паспорт эзэмшигч**

5.1. Дипломат паспортыг дор дурдсан албан тушаалтан эзэмшинэ:

5.1.1. ТӨ-1-ТӨ-Ү1 зэрэг зиндааны төрийн өндөр албан тушаалтан болон тэдгээртэй адилтгах төрийн албан тушаалтны ТӨ-ҮА-ТӨ-Ү1А зэрэглэлд хамаарах албан тушаалтан, тэдний эхнэр буюу нөхөр;

5.1.2. төрийн удирдах албан тушаалын АА-1-АА-3 зэрэглэл, төрийн захиргааны албан тушаалын Т3-12-Т3-13 зэрэглэл, төрийн тусгай

албан тушаалын ТТ-17-ТТ-18 зэрэглэлд хамаарах албан тушаалтан;

5.1.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд асан хүмүүс, тэдний эхнэр буюу нөхөр, насанд хүрээгүй хүүхэд;

5.1.4. Гадаад хэргийн яамны дипломат ажилтан, дипломат элч;

5.1.5. Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн болон Консулын газрын дипломат ажилтан, Засгийн газар хоорондын олон улсын байгууллагад дипломат албан тушаалд ажиллах Монгол Улсын иргэн, тэдний эхнэр буюу нөхөр, насанд хүрээгүй хүүхэд;

5.1.6. Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин цолтой хүмүүс;

5.1.7. Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намын дарга;

5.1.8. төр, засгийн тэргүүн нар гадаадад зорчиход дагалдан явах хамгаалалтын албаны ажилтан.

5.2. Албан паспортыг дор дурдсан албан тушаалтан эзэмшинэ:

5.2.1. төрийн удирдах албан тушаалын АА-4-АА-11 зэрэглэл, төрийн захиргааны албан тушаалын ТЗ-4-ТЗ-11 зэрэглэл, төрийн тусгай албан тушаалын ТТ-5-ТТ-16 зэрэглэлд хамаарах албан тушаалтан;

5.2.2. төрийн үйлчилгээний албан тушаалын ТҮ-11-ТҮ-14 зэрэглэлд хамаарах удирдах албан тушаалтан;

5.2.3. Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намын удирдах зөвлөлийн гишүүн;

5.2.4. Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн болон Консулын газрын үйлчилгээ, техникийн ажилтан, Засгийн газар хоорондын олон улсын байгууллагад үйлчилгээ, техникийн албан тушаалд ажиллах Монгол Улсын иргэн, тэдний эхнэр буюу нөхөр, насанд хүрээгүй хүүхэд;

5.2.5. төрийн өмчийн тавиас дээш хувьтай аж ахуйн нэгжийн захиралд Төрийн өмчийн хорооны тодорхойлолтоор.

5.3. Онцгой тохиолдолд төрийн холбогдох байгууллагын хүсэлтийг үндэслэн гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр Монгол Улсын иргэнд дипломат, албан паспорт олгож болно.

**Зургаа. Үндэсний гадаад паспорт олгох үндэслэл**

6.1. Дипломат, албан паспорт олгоход дор дурдсан материал бүрдүүлнэ:

6.1.1. тухайн албан тушаалтныг томилсон буюу сонгосон төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрийн баталгаажсан хуулбар;

6.1.2. паспорт мэдүүлэх хуудас;

6.1.3. иргэний үнэмлэхийн баталгаажсан хуулбар;

6.1.4. ажлын газрын үнэмлэхийн баталгаажсан хуулбар;

6.1.5. 3.5x4.5 см-ийн хэмжээний цээж зураг гурван хувь (цагаан дэвсгэртэй);

6.1.6. паспортын үнэ, бичилтийн төлбөр төлсөн баримт;

6.1.7. эхнэр буюу нөхөр, насанд хүрээгүй хүүхэд хамт явах бол гэрлэлтийн гэрчилгээ, хүүхдийн төрсний гэрчилгээний баталгаажсан хуулбар.

6.2. Энгийн паспорт олгоход дор дурдсан материал бүрдүүлнэ:

6.2.1. паспорт хүссэн өргөдөл;

6.2.2. иргэний үнэмлэх;

6.2.3. 3.5x4.5 см-ийн хэмжээний цээж зураг гурван хувь;

6.2.4. паспортын үнэ, бичилтийн төлбөр төлсөн баримт.

6.3. Үндэсний гадаад паспортын хүчинтэй хугацааг сунгахад дор дурдсан материал бүрдүүлнэ:

6.3.1. дипломат, албан паспортын хугацааг сунгуулахыг хүссэн тухайн паспорт сунгалтын хуудас, энгийн паспортын хугацааг сунгуулах өргөдөл;

6.3.2. паспорт сунгалтын хураамж төлсөн баримт.

6.4. Энэхүү журмын 3.4-т заасны дагуу хүүхдийн хавсралт үнэмлэх олгох бол дор дурдсан материал бүрдүүлнэ:

6.4.1. хүүхдийн хавсралт үнэмлэх хүссэн эцэг (эх), асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн өргөдөл;

6.4.2. хүүхдийн төрсний гэрчилгээний баталгаажсан хуулбар;

6.4.3. 3.5x4.5 см-ийн хэмжээний цээж зураг хоёр хувь;

6.4.4. хүүхдийн хавсралт үнэмлэхийн үнэ төлсөн баримт.

6.5. Энэхүү журмын 3.4-т заасны дагуу тав хүртэлх настай хүүхдийн зургийг үндэсний гадаад паспортад нааж баталгаажуулах бол дор дурдсан материал бүрдүүлнэ:

6.5.1. хүүхдийн зургийг паспортад нааж хавсаргахыг хүссэн эцэг (эх), асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн өргөдөл;

6.5.2. хүүхдийн төрсний гэрчилгээний баталгаажсан хуулбар;

6.5.3. 3.5x4.5 см-ийн хэмжээний цэж зураг хоёр хувь;

6.5.4. хураамж төлсөн баримт.

6.6. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн үндэсний гадаад паспорт авах тухай мэдүүлэхдээ энэхүү журмын 6.1-6.2-т заасан бичиг баримтыг бүрдүүлж буухиа шуудан, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан Гадаад хэргийн яам, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд ирүүлж болно.

6.7. Дипломат төлөөлөгчийн болон Консулын газарт энгийн паспорт авах тухай мэдүүлэх Монгол Улсын иргэн энэхүү журмын 6.2-т заасан бичиг баримтыг тухайн орноос Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд хүргүүлэх, мөн гарын үсэг зурж баталгаажуулсан паспортаа буцаан авах буухиа шуудангийн зардлаа өөрөө хариуцна.

## Долоо. Үндэсний гадаад паспортыг хадгалах

7.1. Тухайн төрийн байгууллагын Тамгын газар дипломат, албан паспортыг хадгалах бөгөөд түүнийг эзэмшигч албан тушаалтан гадаадад явахад нь олгож, буцаж ирмэгц нь эгүүлэн авч хадгална. Дипломат, албан паспорт эзэмшигч албан тушаалтан ажлаас халагдах буюу чөлөөлөгдөхөд Тамгын газар паспортыг нь хураан авч Гадаад хэргийн яаманд хүлээлгэн өгнө.

7.2. Гадаад хэргийн яам дипломат, албан паспортын хадгалалтад хяналт тавина.

Гадаад хэргийн яам нь хүчингүй болсон дипломат, албан паспортыг бүртгэлээс хасаж устгах бөгөөд эзэмшигч хүсвэл түүнд дурсгал болгон хадгалуулж болно.

7.3. Энгийн паспортыг эзэмшигч өөрөө хадгална.

7.4. Үндэсний гадаад паспортыг үрэгдүүлсэн, гэмтээсэн, бусдад ашиглуулсан, худалдсан, барьцаалсан, хуурамчаар үйлдсэн тохиолдолд гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.5. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн болон Консулын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн алба нь үрэгдүүлсэн, гэмтээсэн болон

шинээр олгосон үндэсний гадаад паспорт, тэдгээрийн хугацааг сунгасан тухай мэдээ болон холбогдох материалыг улирал бүр Гадаад хэргийн яам, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд тус тус ирүүлж байна.

7.6. Хүчин төгөлдөр бус, эсхүл зөрчилтэй үндэсний гадаад паспортыг Хил хамгаалах ерөнхий газар хилийн шалган нэвтрүүлэх боомт дээр хураан авч Гадаад хэргийн яам, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд тус тус шилжүүлнэ.

## Найм. Буцах үнэмлэх

8.1. Буцах үнэмлэхийг үндэсний гадаад паспорт олгох боломжгүй бөгөөд эх орондоо буцаж ирэх Монгол Улсын иргэнд Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн болон Консулын газар олгоно.

8.2. Буцах үнэмлэхийн загварыг гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.3. Гадаад хэргийн яам буцах үнэмлэхийн зарцуулалт, олголтод хяналт тавина.

8.4. Буцах үнэмлэх нь 6 хүртэл сарын хугацаанд эх орондоо буцаж ирэхэд хүчинтэй байна.

8.5. Буцах үнэмлэх олгоход дор дурдсан материал бүрдүүлнэ:

8.5.1. буцах үнэмлэх хүссэн өргөдөл;

8.5.2. буцах үнэмлэх авах болсон нотолгоо (үндэсний гадаад паспортаа үрэгдүүлсэн, гээсэн тухай цагдаагийн байгууллагын тодорхойлолт гэх мэт);

8.5.3. иргэний үнэмлэхийн хуулбар, эсхүл Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн лавлагаа;

8.5.4. 3.5x4.5 см-ийн хэмжээний цэж зураг хоёр хувь;

8.5.5. буцах үнэмлэхийн үнэ төлсөн баримт.

8.6. Буцах үнэмлэх авах иргэн өндөр настан, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа буюу бусад хүндэтгэн үзэх шалтгаантай бол эмнэлгийн байгууллагын албан ёсны дүгнэлт; хорих байгууллага, цагаачлалын албаны түр саатуулах байранд байгаа бол тухайн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн итгэмжлэгдсэн хүнээр буюу баталгаат шуудангаар дамжуулан буцах үнэмлэх олгож болно.



8.7. Буцах үнэмлэхэд Дипломат төлөөлөгчийн болон Консулын газрын тэргүүн, түүний эзгүйд Консулын хэлтсийн дарга, Консул, эсхүл консулын асуудал эрхэлсэн дипломат ажилтан гарын үсэг зурж баталгаажуулна.

8.8. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн болон Консулын газар дараахь материалыг Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд хүргүүлнэ:

8.8.1. буцах үнэмлэх олгосон бичиг баримтыг бүртгэлийн дэвтрийн хамт;

8.8.2. Буцах үнэмлэхийн зарцуулалтын тайлан.

8.9. Хил хамгаалах ерөнхий газар хилийн боомт дээр буцах үнэмлэхийг хураан авч Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд хүргүүлнэ.

## Ес. Хил орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх

9.1. Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай байгуулсан холбогдох олон улсын хэлэлцээрт заагдсан хил орчмын сумдын оршин суугчдад хил орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх олгоно.

9.2. Хил орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх олгох, нэгдсэн бүртгэл хөтлөх, хяналт тавих ажлыг Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, холбогдох олон улсын хэлэлцээрт заагдсан аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэлийн алба, сумын Засаг дарга хариуцна.

9.3. Хил орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх авахад дор дурдсан материал бүрдүүлнэ:

9.3.1. хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх хүссэн өргөдөл;

9.3.2. иргэний үнэмлэхийн баталгаажсан хуулбар;

9.3.3. хялбарчилсан журмаар зорчих үнэмлэхийн үнэ төлсөн баримт.

9.4. Хил орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэхэд холбогдох олон улсын хэлэлцээрт заагдсан аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн албаны дарга, сумын Засаг дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

## Арав. Зорчих үнэмлэх

10.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа харьяалалгүй хүн гадаадад зорчиход түүнд зорчих үнэмлэх олгоно.

10.2. Харьяалалгүй хүнд олгох зорчих үнэмлэхийн загварыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.3. Зорчих үнэмлэхэд Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны дарга, түүний эзгүйд дэд дарга гарын үсэг зурна.

10.4. Харьяалалгүй хүнд зорчих үнэмлэх олгох, нэгдсэн бүртгэл хөтлөх, хяналт тавих ажлыг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба хариуцна.

## Арван нэг. Бусад асуудал

11.1. Гадаад хэргийн яам үндэсний гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичгийн загварыг өөрийн болон гадаад улсын Хилийн шалган нэвтрүүлэх албанд хүргүүлж, гарсан өөрчлөлтийн талаар цаг тухайд нь мэдэгдэх үүрэгтэй.

11.2. Гадаад хэргийн яам үндэсний гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг гарын үсэг зурах албан тушаалтны жагсаалт, гарын үсгийн загвар болон тамга, тэмдэгний дардсыг өөрийн болон гадаадын Дипломат төлөөлөгчийн газар, Хилийн шалган нэвтрүүлэх албанд урьдчилан хүргүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 265958  
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 3